

**Хэдийгээр эх хэл нь биш боловч тухайн хэлийг өндөр түвшинд эзэмшсэн сурагч оролцох боломжтой юу?**

Тийм, хэрэв тухайн сурагч шалгалт бичигдсэн хэл дээр Анхлан суралцагч, дундаж эсвэл түүнээс дээш түвшинд уншиж, бичиж, ярьж, сонсох чадвартай бол боломжтой. Өөрийгөө үнэлэх хүснэгтийг харна уу. Сурагчид бүх дасгал ажлыг бие даан гүйцэтгэж чадах ёстой.

**Шалгалт хэзээ болох вэ?**

Шалгалтыг 2019 оны Арваннэгдүгээр сарын 5-ны өдөр (Сонгуулийн өдөр, сурагчдын амралтын өдөр) Вейкфийлд ахлах сургууль дээр зохион байгуулна. Шалгалтыг зохион байгуулах зөвхөн ганц үндсэн өдөр байгаа. Төгсөхөд кредит шаардлагатай байгаа ахлах ангийн сурагчид Дэлхийн хэлний албатай зөвлөлдөж хавар ямар нэг боломж байгаа эсэхийг лавлах хэрэгтэй.

**Сурагчид хэрхэн бүртгүүлэх вэ?**

Сурагчид онлайн хэлбэрээр: <https://www.apsva.us/world-languages/credit-by-exam/> хаягаар орж бүртгүүлэх боломжтой. Үүний дараагаар орж бүртгүлдтэй холбоо барьж, шалгалт өгөх огноо, хугацаа, байршлыг баталгаажуулах болно.

**Бүртгэл явагдах хугацаа:** Есдүгээр сарын 3-ны өдрөөс Аравдугаар сарын 4-ны өдрийг дуустал

**Ямар ямар хэлний шалгалтууд өгөх боломжтой вэ?**

Америкийн дохионы хэл зэргийг оруулаад ихэнх хэл дээр шалгалт өгөх боломжтой. Тигрин хэлээр яригчдын хувьд бид FCPS-ийн шалгалтыг ашиглах бөгөөд 2 хүртэлх кредитээр тооцно. Анхааруулга: харамсалтай нь бид дараах хэлнүүд дээр шалгалт авах **боломжгүй**: Фульдууд, Каннад, Малагаси, Мам, Хоса хэл. Тав тухыг тань алдагдуулсан явдалд хүлцэл өгье.

**Шалгалтыг хэрхэн үнэлэх вэ?**

Шалгалтыг компьютерээр эсхүл тухайн шалгалтын хэлийг бүрэн эзэмшсэн гаднын хүн үнэлэх болно. Шалгалтын дүн эцсийн байдлаар гарах бөгөөд давж заалдах эрхгүй. Кредитийг дараах хүчин зүйлсэд үндэслэн өгөх болно:

**Сурагчид шалгалтад тэнцсэн бол дүн авах уу?**

Хэрэв амжилттай өгсөн тохиолдолд, сурагчид дүйцүүлэх хичээл(үүд) дээрээ “тэнцсэн” гэсэн дүн авах ба дүнгийн мэдээлэл дээр “P” гэсэн тэмдэглэгээ байх бөгөөд энэ нь тухайн түвшинг амжилттай дүүргэсэн болохыг илтгэнэ. Сурагчид дүнгийн голч (GRA)-д нөлөөлөх үсгээр илэрхийлсэн дүн авахгүй.

Хэлний түвшин	Олгосон кредит	Дараагийн суралцах шат	SFS-ийн дараагийн шат
Анхлан суралцагч өндөр	1.0	II түвшин	SFS I түвшин
Дунд шатны бата	2.0	III түвшин	SFS II түвшин
Дунд шатны дундаж	3.0	IV түвшин	SFS III түвшин
Дунд шатны өндөр	4.0	V түвшин (A.P-г зөвлөхгүй)	V түвшин (A.P-г зөвлөхгүй)

**Дүнг хэрхэн зарлах вэ?**

Дүнгийн мэдэгдлийг Нэгдүгээр сард захиагаар эцэг эхчүүдэд хүргүүлнэ.

**Илүү дэлгэрэнгүй мэдээлэл хаанаас авах вэ?**

Дэлхийн хэлний албаны 703.228.6097 утсаар хандах буюу сургуулийн зөвлөхтэй ярилцаарай.

# Шалгалт өгснөөр авах кредит & Хоёр хэл ЭЗЭМШСЭНИЙГ ИЛГГЭХ ТАМГА

## 2019-20


Дэлхийн хэлний алба



2110 Washington Blvd. Утас: 703.228.6097  
Arlington VA 22204 [apsva.us/worldlanguages](http://apsva.us/worldlanguages)



Arlington  
Public  
Schools



## Шалгалт өгснөөр авах кредит гэж юу вэ?

Арлингтоны улсын сургуулиуд (ABS) Англиас бусад хэл дээр ойлгох, харилцан ярих чадвартай сурагчдад сонгогдсон зарим гадаад хэлний шалгалт өгөх замаар ахлах сургуулийн кредит авах боломжийг

олгодог. Шалгалт өгснөөр авах кредит нь сурагчдын гадаад хэлний түвшинг тогтоох замаар гадаад хэлний дөрөв хүртэлх кредит олгодог. Бид ихэнх хэлний хувьд STAMP, AAPP, PPI болон WPI гэх мэт үндэсний стандарт шалгалтууд ашигладаг.

## Шалгалт өгч авах кредитийг ашиглах нь сурагчдад ямар ашигтай вэ?

Хэрэв сурагчид Ахисан шатны сургалтын диплом (ASD)-той төгсөхийг хүсвэл тэд гадаад хэлний кредит авах хэрэгтэй болно. Түүнийг авахын тулд нэг хэлний гурван жил/кредит (3 x 1) эсхүл хоёр өөр хэлний хоёр жил/кредит (2 x 2) авах хэрэгтэй.

## Шалгалт өгснөөр хэдэн кредит авах боломжтой вэ?

Өгч буй шалгалтнаас хамаараад хоёр хүртэлх эсхүл шалгалтын дүнг харж тухайн хэлийг эзэмшсэн түвшинд үндэслэн дөрөв хүртэлх кредит авах боломжтой. Хэрэв аливаа сурагч хэлний үр чадварын улмаас III эсхүл IV түвшний ангид орсон бол шалгалт өгснөөр өмнөх доогуур түвшинд нь кредит авах боломжтой. Хэрэв аливаа сурагч III түвшний ангид элсэн ороод шалгалт өгснөөр 4 кредит авсан бол дүнгийн хуудас дээр зөвхөн нэг л кредит нэмэгдэн бичигдэх боломжтой. **Нэг ижил хэлний хичээлээс олон кредит авах боломжгүй.**

## Тус шалгалтын дүн нь Хоёр хэл эзэмшсэнийг илтгэх тамга авахад хэрхэн дэмжлэг болно вэ?



2015-16 оноос хойш, Болговсролын зөвлөлийн Хоёр хэл эзэмшсэнийг илтгэх тамга нь төгсөх ангийн ахлах сургуулийн сурагчдын Англи хэлнээс гадна нэг буюу түүнээс дээш хэлний түвшин эзэмшсэн болохыг гэрчилдэг. Англи хэлний хичээлийн эцсийн шалгалтад бүрэн эзэмшсэн эсхүл түүнээс дээш түвшинд (11 дүгээр анги SLL) эзэмшсэн байдлаар бүгдэд нь тэнцэж, өөр хэлний үндэсний стандарт шалгалтад дунд шатны дундаж түвшин буюу түүнээс дээш түвшингийн оноо авсан сурагчдад Хоёр хэл эзэмшсэнийг илтгэх тамга олгогдоно. Хоёр хэл эзэмшсэнийг илтгэх тамга нь сурагчийн ахлах сургуулийн диплом дээр дарагдана.

## Хэн тус шалгалтыг өгөх эрхтэй вэ? Хэрхэн шалгалт өгөх түвшний хэлний мэдлэг эзэмшсэн болохоо мэдэх вэ?

Хэлний мэдлэгийн түвшин нь хамгийн багадаа Анхлан суралцагчийн дунд шатанд бөгөөд дараахыг хийх чадвартай бол 7-оос 12-р ангийн сурагчид эрхтэй байж болно.

- Энгийн хялбар асуулт асуух, хариулт өгөх.
  - Өөр хүнтэй хийх харилцан ярианд хариу болгон энгийн хялбар өгүүлбэр хэлэх.
  - Ойр зуурын, суурь мэдээлэл ойлгуулах.
  - Дуртай, дургүй зүйлсээ илэрхийлэх.
  - Энгийн хялбар анкет бөглөх.
  - Өдөр тутам хийдэг зүйлсийн талаар бичих, унших.
- <http://www.apsva.us/worldlanguages> хаягаар орж авах боломжтой Өөрийгөө үнэлэх хүснэгтийг харна уу

**Хэрэв та ESL/MLL А болон В авч буй сурагч бол бүртгэлийн хуудас дээрээ тэдгээр үйлчилгээг авч буй талаар тэмдэглэл хийснээр бид танд өөр шалгалт өгөх болно.**

## Энэ шалгалтыг хэн өгөх ХЭРЭГТҮЙ ВЭ?

- IV түвшний эсхүл SES III түвшний антид элсэн суралцагчид хавар өөрсдийн антидаа тус шалгалтыг өгөх учраас одоо өгөх шаардлагагүй.
- Өмнө гадаад хэлний хичээл дээр авсан дүнгээ сайжруулахыг хүссэн сурагчид.

## Ямар төлбөртэй вэ?

Арлингтоны улсын сургуулийн анх удаа шалгалт өгч буй сурагчид ямар нэг төлбөр төлөхгүй. Дахин шалгалт өгөх тохиолдолд төлбөрийг сурагч өөрөө хариуцах бөгөөд шалгалтнаасаа хамаараад төлбөр нь харилцан адилгүй байна.